



POLSKA AKADEMIA NAUK

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ-АРД УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ,  
ПОЛЬШИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ХООРОНД ЭРДЭМ ШИНЖИЛ-  
ГЭЭНИЙ ТАЛААР 1971-1972 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ  
Т Ө Л Ө В Л Ө Г Ө Ө.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын шинжлэх ухааны академи,  
Польшийн шинжлэх ухааны академийн хооронд эрдэм шинжилгээний  
талаар хамтран ажиллах тухай 1961 оны 9-р сарын 29-ний өдөр  
Варшав хотноо байгуулагдсан Хэлэлцээрийн дагуу Бүгд Найрамдах  
Монгол Ард Улсын Шинжлэх ухааны академи, Польшийн шинжлэх ухаа-  
ны академийн хооронд 1971-1972 онд эрдэм шинжилгээний талаар  
хамтран ажиллах асуудлын талаар хоёр Академийн төлөөлөгчид 1970  
оны арван хоёрдугаар сарын 22-23-ний өдрүүдэд хэлэлцээ хийв.

Энэхүү Хэлэлцээнд:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх ухааны академийн  
талаас,

1. Проф. док-р Базарын Ширэндэв-Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Шинжлэх ухааны академийн ерөн-  
хийлөгч, академич, төлөөлөгчдийн тэр-  
гүүн.

2. Намсрайн Пүрэвжав -Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинж-  
лэх ухааны академийн гадаад харилцаа-  
ны хэлтсийн ажилтан.

Польшийн Шинжлэх ухааны академийн талаас,

1. Проф. док-р Януш Грошковски-Польшийн Шинжлэх ухааны ака-  
демийн Ерөнхийлөгч, академич, төлөөлөгч-  
дийн тэргүүн.

2. Проф. док-р Зофия

Келян Яворовска-Польшийн Шинжлэх ухааны академийн  
Палеозологийн Институтын захирал,  
Польшийн Шинжлэх ухааны академийн сур-  
валжлагч гишүүн.



POLSKA AKADEMIA NAUK

2.

3. Проф, док-р-Витольд Дыновски-Польшийн Шинжлэх ухааны академийн соёл дурсгалын түүх судлах хүрээлэнгийн профессор.

4. Мгр. Кароль Беда-Польшийн Шинжлэх ухааны академийн гадаадтай шинжлэх ухааны талаар харилцах товчооны ажилтан нар оролцов.

Хоёр талын төлөөлөгчид санал солилцох явцад Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх ухааны академи, Польшийн Шинжлэх ухааны академийн хооронд хамтын ажиллагаа өнгөрсөн 1969-1970 онд эрдэмтэд харилцан солилцох, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дэвсгэр дээр эртний амьтны судлалын талаар монгол польшийн хамтарсан хайгуул зохион явуулах, түүнчлэн тогтмол ном хэвлэл солилцох хэлбэрээр мэдэгдэхүйц хөгжиж байгааг сэтгэл хангамжтай тэмдэглэв.

Төлөөлөгчид хоёр академийн хооронд эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг цаашид бэхжүүлэн гүнзгийрүүлэх хүсэл эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэв.

Хоёр талын төлөөлөгчид харилцан ойлголцох нөхөрсөг байдалд явагдсан Хэлэлцээний үр дүнд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх ухааны академи, Польшийн Шинжлэх ухааны академийн хооронд 1971-1972 онд эрдэм шинжилгээний талаар хамтран ажиллах тухай дор дурдсан төлөвлөгөөнд гарын үсэг зурахаар тохиролцов.

Нэгдүгээр зүйл.

Хоёр академи эрдэм шинжилгээний ажил хамтран явуулах, туршлага солилцох, зөвлөлгөө авах, эрдэм шинжилгээний арга хэмжээнд оролцох зорилгоор 1971-1972 онд тэгш солилцооны үндсэн дээр эрдэм шинжилгээний 1-2 ажилтныг жил бүр 8 долоо хоногийн хугацаагаар харилцан солилцоно.

Томилогдох хүмүүсийн ажлын сэдэв, хөтөлбөр хугацааны тухай жил бүрийн эхэнд бичгээр тохиролцож байна.



## POLSKA AKADEMIA NAUK

3.

Энэхүү зүйлийн үндсэн дээр эрдэмтдийг томилон явуулахтай холбогдсон санхүүгийн нөхцлийг хүлээн авагч орны дотоод мөрдөгдөж байгаа хууль дүрмийн дагууд тогтооно.

### Хоёрдугаар зүйл.

Хоёр Академийн өөрсдийн зарим эрдэмтдийг тэдний зардлаар нь эрдэм шинжилгээний ажлаар томилон явуулж байна.

Томилогдон явах хүмүүсийн ажлын программ,сэдвийн тухай хоёр тал бичгээр жич тохиролцоно.

### Гуравдугаар зүйл.

Хоёр академи өөрсдийн зохион байгуулалт,олон улсын байгууллагад гишүүнээр элсэн орох,олон улсын эрдэм шинжилгээний их бага хурал,симпозиум,уулзалтанд оролцох болон академийн үйл ажиллагааны тухай харилцан мэдээлэж байна.

### Дөрөвдүгээр зүйл.

Хоёр Академи эрдэм шинжилгээний чанартай тогтмол ном хэвлэл,жил бүрийн жагсаалтыг харилцан солилцож байна.

### Тавдугаар зүйл.

Академиуд нь хоёр орны ард түмний үндэсний баярыг тохиолдуулан онолын бага хурал зохиох,улс ардын аж ахуй,соёл шинжлэх ухааны хөгжилтийн тухай хэвлэлд өгүүлэл нийтлэх,лекц яриа хийх,үзэсгэлэн гаргах зэрэг арга хэмжээг зохион явуулна.

Энэ зорилгоор:

—Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Академи,Монголд ардын хувьсгал ялсны 50 жилийн ойг тохиолдуулан 1971 оны 4-р сард Улаанбаатар хотноо зохиогдох эрдэм шинжилгээний хуралд Польшийн Шинжлэх ухааны академийн нэгэн төлөөлөгчийг урьж оролцуулна.

Уг төлөөлөгчийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсад байхтай холбогдох бүх зардлыг монголын тал хариуцана.

—Польшийн Шинжлэх ухааны академи Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх социалист бүтээн байгуулалтын амжилтын



## POLSKA AKADEMIA NAUK

4.

талаар зарим судалгаа явуулах болон БНПАУ, БНМАУ-ын хоорондын улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухааны харилцааны тухай лекц уншуулах зорилгоор нэг хүнийг тэгш солилцооны шугамаар БНМАУ-д явуулна.

### Зургаадугаар зүйл.

Хоёр академийн төлөөлөгчид эртний амьтны судлалын хай - гуулд оролцож байгаа ажилтны хүчийг 1971-1972 онуудад урьдах жилүүдэд цуглуулсан олдвор материалыг хамтран боловсруулж дуусгах, хайгуулын эрдэм шинжилгээний ажлын дүнг шинэ баяжуулалт, саналтайгаар тайлагнан гаргахад чиглүүлэн ажиллах нь зүйтэй гэх үзэв.

Үүнтэй холбогдуулан хоёр Академийн төлөөлөгчид монгол польшийн палеонтологийн хамтарсан хайгуулын үйл ажиллагааны тухай асуудал авч хэлэлцээд, 1971-1972 онд зохион явуулах ажлынхаа хэмжээ, зохион байгуулалтыг тодорхойлсон дүрэм боловсруулж гарын үсэг зурахыг уг хайгуулын ангийн удирдлагад үүрэг болгов.

### Долоодугаар зүйл.

Польшийн эрдэмтэд өөрийн зардлаар Төв аймгийн Баян сум дахь монгол-польшийн найрамдлын нэрэмжит хөдөө аж ахуйн нэгдлийн нутаг түүний ойролцоо зарим газруудад физик газар зүй, угсаа судлалын талаар хамтарсан хайгуулын ажил зохион явуулах санал тавьсныг БНМАУ-ын Шинжлэх ухааны академи зөвшөөрч байгаагаа илэрхийлэв.

Монголын тал дээрхи судалгааг зохион явуулах, орчуулагч олж өгөх зэрэг ажилд бололцооны хирээр туслалцаа дэмэлэг үзүүлнэ.

### Наймдугаар зүйл.

Хоёр Академи тус тусын оронд зохиогдож байгаа эрдэм шинжилгээний олон улсын их, бага хурал, семинар зэрэг арга хэмжээнд төлөөлөгчидөө урьж оролцуулна.



Есдүгээр зүйл.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх ухааны академи, Польшийн Шинжлэх ухааны академийн хооронд эрдэм шинжилгээний талаар хамтран ажиллах энэхүү Төлөвлөгөө нь Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Польш Ард Улсын хооронд соёлын талаар 1971-1972 онд хамтран ажиллах Төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг болно.

Аравдугаар зүйл.

Энэхүү Төлөвлөгөө нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдийн газар, Польшийн Шинжлэх ухааны академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нарын газраар батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцэн тохирогч Талууд нь энэ тухай харилцан бие биедээ бичгээр мэдэгдэх болно.

Арваннэгдүгээр зүйл.

Энэ Төлөвлөгөөг биелүүлэх явцад ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах шаардлага гарвал хоёр Академи энэ асуудлын талаар бичгээр буку дипломат шугамаар харилцан хич тохиролцож байна.

Энэхүү Төлөвлөгөөг 1970 оны арван хоёрдугаар сарын 23-ны өдөр Варшав хотноо монгол, польш хэл дээр тус бүр нийтгээд хувь үйлдэж гарын үсэг зурав.

Хоёр эх хувь нэгэн адил хүчин төгөлдөр болно.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД  
УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКА-  
ДЕМИЙН ӨМНӨӨС  
БРӨНХИЙЛЭГЧ

Б.ШИРЭНДЭВ.

*Б.Ширэндэв*

ПОЛЬШИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ  
АКАДЕМИЙН ӨМНӨӨС

БРӨНХИЙЛЭГЧ

Я.ГРОШКОВСКИ.

*Я.Грошковски*